

ЗӨВЛӨЛИЙН ШИЙДВЭР (ЕХ) 2020/1998

2020 оны 12 дугаар сарын 7

Хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийн эсрэг авах хориг арга хэмжээ

ЕВРОПЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛ

Европын холбооны гэрээний 29 дүгээр зүйлд үндэслэн,

Европын холбооны зөвлөл болон Европын холбооны Гадаад харилцаа, Аюулгүй байдлын бодлогын асуудал эрхэлсэн Дээд төлөөлөгчийн хамтарсан саналд тулгуурлан,

- (1) Европын холбоо нь хүний нэр төр, эрх чөлөө, ардчилал, тэгш байдал, эрх зүйт ёс, хүний эрхийг дээдлэх үнэт зүйлсэд тулгуурладаг бөгөөд гадаад үйл ажиллагааны хүрээнд энх тайван, тогтвортой аюулгүй байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг эдгээр үнэт зүйлсийг хамгаалахыг зорьж байна.
- (2) Хүний эрх нь бүх нийтийн, үл хуваагдах, харилцан хамаарал бүхий шинжтэй байдаг. Улс орнууд олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийн хэрэгжилтийг хангах үүрэгтэйгээс гадна хүний эрхийг хүндэтгэх, хамгаалах, хэрэгжүүлэх үндсэн үүргийг хүлээнэ. Дэлхийн даяар хүний эрх зөрчигдөж байгаа явдалд төрийн бус оролцогчид ихээхэн оролцоотой байгаа бөгөөд энэ асуудал нь анхаарал татсан хэвээр байна. Эдгээр үйлдэл нь Европын холбооны гэрээний (TEU) 21-р зүйлийн (1), (2) -т заасан зарчмуудыг зөрчиж, Холбооны гадаад үйл ажиллагаанд заналхийлэл учруулж байна.
- (3) 2019 оны 12-р сарын 9-ний өдөр Зөвлөлөөс Европын холбооны гадаад харилцаа, аюулгүй байдлын бодлогын асуудал хариуцсан Дээд төлөөлөгчөөр дамжуулан хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийн эсрэг авах нэгдсэн хориг арга хэмжээг боловсруулах бэлтгэл ажлыг эхлүүлсэн.
- (4) Энэхүү шийдвэрээр дэлхий даяар хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийн эсрэг авах хориг арга хэмжээний тогтолцоог бий болгоно. Үүнтэй холбогдуулан Зөвлөлөөс энэ шийдвэрийн хүрээнд хориг арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийн ач холбогдол болон олон улсын хүний эрх, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн харилцан үйлчлэлийг тусгайлан авч үзнэ. Энэхүү шийдвэр нь гадаад болон аюулгүй байдлын бодлогын нийтлэг зорилтын хүрээнд хүний эрхийн зөрчил, хүчирхийллийн талаар тодорхой гуравдагч орнуудын нөхцөл байдлыг харгалзан үзэж, хориг арга хэмжээг тогтоох тухай Зөвлөлийн одоогийн болон ирээдүйд гарах бусад шийдвэрийн хэрэгжилтэд нөлөөлөхгүй.
- (5) Эдгээр хориг арга хэмжээ нь TEU 21-р зүйлд заасан гадаад болон аюулгүй байдлын бодлогын нийтлэг зорилтуудыг хангах, TEU 21 дүгээр зүйлийн 21(2) дах хэсэгт заасны дагуу Холбооноос ардчилал, эрх зүйт ёс, хүний эрх, олон улсын эрх зүйн зарчмуудыг нэгтгэн бэхжүүлэх, дэмжих үйл ажиллагаанд дэм болно. Эдгээр хориг арга хэмжээг хэрэгжүүлэх явдал нь Холбооны ерөнхий стратегид нийцэх бөгөөд Холбооны хүний эрхийг дэмжих чадавхийг нэмэгдүүлнэ.

- (6) Тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхэд Холбооны цаашдын үйл ажиллагаа шаардлагатай.

ЭНЭ ШИЙДВЭРИЙГ БАТАЛСАН:

1 дүгээр зүйл

1. Энэхүү Шийдвэрээр дэлхий даяар хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийг арилгахад чиглэсэн хориг арга хэмжээг бий болгоно. Үүнд дараах тохиолдлууд хамаарна:
 - (a) Геноцид буюу төрлөөр устгах
 - (b) Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг
 - (c) Хүний эрхийн ноцтой зөрчилд дараах тохиолдуудыг хамруулна.
 - (i) эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандах
 - (ii) боолчлох
 - (iii) шүүхээс гадуур дур мэдэн цаазаар авах
 - (iv) хүчээр алга болгох
 - (v) дур мэдэн баривчлах, цагдан хорих
 - (d) Хүний эрхийн бусад ноцтой зөрчил нь дараах тохиолдлуудаар хязгаарлагдахгүй бөгөөд өргөн цар хүрээ бүхий зохион байгуулалтын шинжтэй зөрчил эсхүл Европын холбооны олон улсын гэрээний 21-р зүйлд заасан гадаад бодлого, аюулгүй байдлын нийтлэг зорилтуудын хувьд ноцтой гэж тооцогдох тохиолдлууд хамаарна:
 - (i) энэ зүйлд заасны дагуу хүнийг наймаалах, шилжин суурьшигчдыг хууль бусаар газраар, далайгаар болон агаараар нэвтрүүлэхтэй холбоотойгоор хүний эрхийг зөрчих;
 - (ii) бэлгийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл;
 - (iii) тайван цугларах, эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг зөрчих;
 - (iv) үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг зөрчих;
 - (v) шашин шүтэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөөг зөрчих;
2. 1 дэх хэсгийг хэрэглэхдээ олон улсын заншлын эрх зүй, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн баримт бичгүүдийг харгалзан үзэх ёстой:
 - a) Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
 - b) Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт
 - c) Төрлөөр устгах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тийм гэмт хэрэг үйлдэгчдийг шийтгэх тухай конвенц
 - d) Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц
 - e) Арьс үндсээр алагчилах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенц
 - f) Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц
 - g) Хүүхдийн эрхийн тухай конвенц
 - h) Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай олон улсын конвенц
 - i) Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц

- j) НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн конвенцийн нэмэлт, хүн ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдийг худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох ба шийтгэх тухай протокол
 - k) Олон Улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
 - l) Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенц
3. Энэ журмыг хэрэгжүүлэх зорилгын хүрээнд хувь хүн, хуулийн этгээд аж ахуй нэгж, байгууллага гэдэгт дор дурдсаныг ойлгоно:
- a) Төр, түүнийг төлөөлж буй албан тушаалтнууд
 - b) Тухайн нутаг дэвсгэр дээр удирдан зохион байгуулах хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэгч бусад оролцогчид, албан тушаалтнууд
 - c) Бусад төрийн бус оролцогчид
4. 3 дугаар зүйлийн (c) хэсэгт заасан бусад төрийн бус оролцогчдыг Хавсралтын жагсаалтад шинээр оруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Зөвлөл дараах онцлог бүхий шинж байдлыг харгалзан үзнэ:
- a) TEU 21 дүгээр зүйлд заасан гадаад болон аюулгүй байдлын бодлогын нийтлэг бодлогын зорилтууд
 - b) Хүчирхийллийн хэмжээ, үр нөлөө

2 дугаар зүйл

1. Гишүүн улсууд Хавсралтад заасны дагуу дараах тохиолдолд өөрсдийн нутаг дэвсгэрт нэвтрэх, дамжин өнгөрөхийг хязгаарлахад шаардлагатай арга хэмжээг авах ёстой:
- (a) 1 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан хариуцлага хүлээвэл зохих хувь хүн
 - (b) 1 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, захиалах, туслах, бэлтгэх, хөнгөвчлөх, урамшуулах байдлаар санхүүгийн, техникийн болон материаллаг дэмжлэг үзүүлдэг эсхүл бусад хэлбэрээр оролцдог хувь хүн
 - (c) (a) болон (b) хэсэгт заасан хувь хүнтэй хамтран ажилласан хувь хүн
2. 1 дүгээр зүйл нь Гишүүн улсуудад өөрийн улсын иргэдийг нутаг дэвсгэртээ нэвтрэхээс татгалзах үүргийг хүлээлгэх ёсгүй.
3. 1 дүгээр зүйл нь Гишүүн улс дор дурдсаны дагуу олон улсын эрх зүйн үүрэг хүлээсэн тохиолдолд хамаарахгүй:
- (a) олон улсын засгийн газар хоорондын байгууллагын хүлээн авагч улсын хувьд;
 - (b) НҮБ-ын урилгаар эсхүл түүний ивээл дор зарласан олон улсын бага хурлыг зохион байгуулагч улсын хувьд;
 - (c) Дархан эрх, эрх ямба олгох тухай олон талт гэрээний дагуу; эсхүл
 - (d) 1929 оны Латераны пактын дагуу
4. Гишүүн улс Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (ЕАБХАБ) -ын хүлээн авагч улс болсон тохиолдолд 3 дугаар заалтыг хэрэглэнэ.

5. Гишүүн улс 3 болон 4 дэх хэсгийн дагуу үүргээс чөлөөлөхийг хүлээн зөвшөөрсөн бүхий л тохиолдолд Зөвлөлд зохих ёсоор мэдээллэх ёстой.
6. Гишүүн улсууд хүмүүнлэгийн яаралтай хэрэгцээ шаардлага гарсан, Холбооноос зохион байгуулах засгийн газар хоорондын хуралдаан, уулзалтад оролцох болсон, эсхүл ЕАБХАБ-ын даргалагчаар хүний эрхийн ноцтой зөрчил, хүчирхийллийн эсрэг авах арга хэмжээний хүрээнд улс төрийн хэлэлцээр зохион байгуулах болсон тохиолдолд 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнээс чөлөөлж болно.
7. Гишүүн улсууд шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх зорилгоор нэвтрэх буюу дамжин өнгөрөх шаардлагатай тохиолдолд 1 дэх хэсэгт заасан арга хэмжээнээс чөлөөлж болно.
8. 6 болон 7 дугаар хэсэгт заасны дагуу чөлөөлөхийг хүлээн зөвшөөрч буй Гишүүн улс энэ талаар Зөвлөлд бичгээр мэдэгдэнэ. Зөвлөлийн нэг буюу хэд хэдэн гишүүн тухайн мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын хоёр өдрийн дотор бичгээр эсэргүүцэл гаргаагүй бол тухай мэдэгдлийг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Зөвлөлийн нэг буюу хэд хэдэн гишүүн эсэргүүцэл гаргасан тохиолдолд Зөвлөл нь шаардлага хангасан олонхийн саналаар тухайн мэдэгдлийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлыг шийдвэрлэж болно.
9. 3, 4, 6, 7, 8 дугаар хэсэгт заасны дагуу Гишүүн улс хавсралтад заасан этгээдэд өөрийн нутаг дэвсгэрээр нэвтрэх, дамжин өнгөрөхийг хүлээн зөвшөөрсөн бол уг зөвшөөрөл нь зориулалтын дагуу тухайн этгээдээр хязгаарлагдана.

3 дугаар зүйл

1. Хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дараах этгээдүүд эзэмшиж, өмчлөж, захиран зарцуулах бөгөөд Хавсралтад заасны дагуу хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг нь царцаана:
 - (a) 1 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан хариуцлага хүлээвэл зохих хувь хүн, хуулийн этгээд, аж ахуй нэгж, байгууллага,
 - (b) 1 дүгээр зүйлийн (1) дэх хэсэгт заасан үйл ажиллагааг төлөвлөх, удирдан чиглүүлэх, захиалах, туслах, бэлтгэх, хөнгөвчлөх, урамшуулах байдлаар санхүүгийн, техникийн болон материаллаг дэмжлэг үзүүлдэг эсхүл бусад хэлбэрээр оролцдог хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагууд
 - (c) (a) болон (b) хэсэгт заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагатай хамтран ажилладаг хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагууд
2. Хавсралтад заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад шууд болон шууд бус байдлаар хөрөнгө оруулалт хийх, хөрөнгө бий болгож болохгүй.
3. 1 болон 2 дах заасан үүргээсээ ухрах замаар, Гишүүн улсуудын эрх бүхий байгууллагууд зохистой гэж үзвэл царцаасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг

чөлөөлөх эсхүл тодорхой хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг ашиглах боломжийг олгож болно. Үүнд:

- a) Хавсралтад заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагын түүний асрамжид байдаг гэр бүлийн гишүүдийн үндсэн хэрэгцээ. Үүнд, хоол, байрны түрээс, моргежийн төлбөр, эм, эмчилгээний төлбөр, татвар, даатгалын шимтгэл, нийтийн хэрэгслийн төлбөр зэрэг орно.
- b) Үндэслэл бүхий мэргэжлийн үйлчилгээний төлбөр эсхүл хууль зүйн үйлчилгээтэй холбоотойгоор гарсан нөхөн төлөх зардал
- c) Царцаасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг хадгалах, арчлах, засч сайжруулахад шаардагдах төлбөр, үйлчилгээний хөлс
- d) Холбогдох эрх бүхий байгууллагаас шаардлагатай нэмэлт зардал олгох ёстой гэж үзсэн үндэслэлээ дор хаяж хоёр долоо хоногийн өмнө бусад Гишүүн улсуудын эрх бүхий байгууллага болон Комисст мэдэгдсэн бол
- e) Дипломат буюу консулын төлөөлөгчийн газар эсхүл олон улсын хууль тогтоомжийн дагуу дипломатын дархан эрх, эрх ямба эдэлдэг олон улсын байгууллагаас албан зорилгоор ашиглахаар төлөвлөсөн данс, данснаас төлөх төлбөр

Холбогдох Гишүүн улс 1 дэх хэсэгт заасны дагуу зөвшөөрөл олгосноос хойш хоёр долоо хоногийн дотор бусад Гишүүн улсууд болон Хороонд мэдэгдэнэ.

4. 3 дугаар зүйлд заасан үүргээсээ ухрах замаар, Гишүүн улсуудын эрх бүхий байгууллагууд дараах нөхцлүүд хангагдсан тохиолдолд царцаагдсан тодорхой хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг чөлөөлөхийг зөвшөөрч болно.
 - a) хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь 3 дугаар зүйлд заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагыг Хавсралт I-д тусгасан өдрөөс өмнө гарсан арбитрын шийдвэр, Холбооны шүүхийн болон захиргааны шийдвэр, эсхүл Гишүүн улсын гүйцэтгэх боломжтой шүүхийн шийдвэрт тусгагдсан бол
 - b) хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг дээрх шийдвэрт хүчин төгөлдөр гэж үзэж, холбогдох шаардлагыг хангах зорилгоор шаардах эрх бүхий этгээдийн эрхийг зохицуулсан хууль тогтоомжийн хүрээнд ашиглах бол
 - c) шийдвэр нь Хавсралт I-д заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагын ашиг сонирхолд чиглэгдээгүй байх
 - d) шийдвэрийг хүлээн зөвшөөрөх явдал нь тухайн Гишүүн улсын нийтийн бодлогод харшлаагүй байх

Холбогдох Гишүүн улс 1 дэх хэсэгт заасны дагуу олгох зөвшөөрлийг зөвшөөрөл олгосноос хойш хоёр долоо хоногийн дотор бусад Гишүүн улсууд болон Хороонд мэдэгдэнэ.

5. 1 дүгээр хэсэг нь Холбогдох Гишүүн улс Хавсралтад заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаас төлбөрийг шууд болон шууд бус байдлаар хүлээн аваагүй гэж шийдвэрлэснээс бусад тохиолдолд тухайн хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагаас байгуулсан гэрээ, хэлцлийн дагуу төлөх ёстой төлбөр, эсхүл тухайн төлбөрийн үүрэг үүсэхээс өмнө бий босон үүрэг хариуцлагыг зогсоож болохгүй.
6. 2 дах хэсэг нь дараах царцаасан дансанд нэмэлт оруулахад хамаарахгүй:

- (a) дансны хүү эсхүл бусад орлого;
- (b) 1 болон 2 дах хэсэгт заасан арга хэмжээг хэрэгжүүлэхээс өмнө байгуулагдсан гэрээ, хэлцлийн дагуу төлөх төлбөр
- (c) Холбооны хүрээнд гаргасан болон холбогдох Гишүүн улсад гүйцэтгэх боломжтой гэж үзсэн шүүхийн, захиргааны болон арбитрын шийдвэрийн дагуу төлөх төлбөр

4 дүгээр зүйл

1. 3 дугаар зүйлийн 1, 2 дах хэсэгт заасан үүргээсээ ухрах замаар, Гишүүн улсуудын эрх бүхий байгууллагууд хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр нь зохистой буюу эм, эмнэлгийн хэрэгсэл, хоол хүнс, хүмүүнлэгийн ажилчид болон холбогдох тусламжийг шилжүүлэх, нүүлгэн шилжүүлэх зэрэг хүмүүнлэгийн зорилгыг хангахад зайлшгүй гэж үзсэн бол царцаасан хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг чөлөөлөх эсхүл тодорхой хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг ашиглах зөвшөөрлийг олгож болно.
2. Холбогдох Гишүүн улс энэ зүйлд заасны дагуу зөвшөөрөл олгосноос хойш дөрвөн долоо хоногийн дотор бусад Гишүүн улсууд болон Хороонд мэдэгдэнэ.

5 дугаар зүйл

1. Зөвлөл нь Гишүүн улс болон Дээд төлөөлөгчийн саналд тулгуурлан нэгдмэл байх зарчмын дагуу ажиллах бөгөөд Хавсралтад заасан жагсаалтыг шинээр оруулах, түүнд нэмэлт өөрчлөлт оруулна.
2. Зөвлөл нь 1 дэх хэсэгт заасны дагуу Хавсралтад заасан жагсаалтад хувь хүн, хуулийн этгээд, аж ахуй нэгж, байгууллагыг шинээр оруулах тухай шийдвэрийг хаяг нь мэдэгдэж байгаа тохиолдолд тухайн этгээдэд шууд, эсхүл мэдэгдэл хэлбэрээр нийтлэн мэдээллэж, тухайн этгээдийг хянан ажиглалт хийх боломжоор хангана.
3. Хэрэв хянан ажиглалт ирүүлсэн, эсхүл шинээр баримт нотолгоо гаргаж өгсөн бол Зөвлөлөөс 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг хянаж үзээд холбогдох хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагад мэдэгдэнэ.

6 дугаар зүйл

1. Хавсралтад 2 болон 3 дугаар зүйлд заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагыг жагсаасан үндэслэлийг заана.
2. Хавсралтад холбогдох хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг тусгана. Хувь хүмүүсийн мэдээлэлд дараах зүйлс багтана: албан ёсны нэр ба бусад нэр; төрсөн он сар өдөр, төрсөн газар; харьяалал; паспорт, иргэний үнэмлэхний дугаар; хүйс; хэрэв мэдэгдэх боломжтой бол гэрийн хаяг; эрхлэх чиг үүрэг эсхүл мэргэжил. Хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагын мэдээлэлд дараах зүйлс багтана: нэр, бүртгүүлсэн газар, огноо; регистрийн дугаар; үйл ажиллагаа эрхэлдэг хаяг.

7 дугаар зүйл

1. Зөвлөл болон Дээд төлөөлөгчөөс энэхүү Шийдвэрийн дагуу дараах албаны үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хувийн мэдээлэлд боловсруулалт хийнэ. Тухайлбал:
 - (a) Зөвлөлөөс Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хангах
 - (b) Дээд төлөөлөгчөөс Хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах бэлтгэл ажлыг хангах
2. Зөвлөл болон Дээд төлөөлөгчөөс жагсаалтад заасан хувь хүмүүсийн үйлдсэн гэмт хэргийн байдал, холбогдох эрүүгийн шийтгэл, аюулгүй байдлын арга хэмжээтэй холбоотой мэдээлэлд боловсруулалт хийж болох бөгөөд энэ нь зөвхөн хавсралтыг бэлтгэхэд шаардлагатай хэр хэмжээнд байна.
3. Энэхүү Шийдвэрийн зорилгыг хангах үүднээс Зөвлөл болон Дээд Төлөөлөгч нь Европын Парламент, Зөвлөлийн Журам (EU) 2018/172-ын 3 дугаар зүйлийн (8) дах хэсэгт заасны дагуу холбогдох хувь хүний мэдээллийг боловсруулах ажиллагаанд “хянагч”-аар томилогдсон.

8 дугаар зүйл

Энэхүү Шийдвэрийн дагуу авсан арга хэмжээний үр дүнд шууд буюу шууд бус байдлаар, бүхэлдээ буюу хэсэгчлэн нөлөөнд орсон дараах этгээдүүдийн байгуулсан аливаа гэрээ, хэлцэлтэй холбоотой нэхэмжлэл, үүнд нөхөн төлбөр, баталгаа гаргуулах шаардлага, бондын хугацааг сунгах, бондын төлбөр гаргуулах, санхүүгийн баталгаа, нөхөн төлбөр гаргуулах зэрэг аливаа хэлбэрийн бүхий л шаардлагыг дараах этгээдүүд хариуцан биелүүлнэ:

- (a) Хавсралтад заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуй нэгж, байгууллага
- (b) (a) хэсэгт дурдсан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагын аль нэгээр дамжуулан эсхүл тэдгээрийг төлөөлөн үйл ажиллагаа явуулж буй аливаа хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллага.

9 дүгээр зүйл

Энэхүү шийдвэрт тусгагдсан арга хэмжээний үр нөлөөг хамгийн дээд хэмжээнд байлгах үүднээс Холбооноос гуравдагч орнуудад энэхүү шийдвэрт заасантай адил хориг арга хэмжээ авахыг уриалж ажиллана.

10 дугаар зүйл

Энэхүү шийдвэр нь 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл хэрэгжих бөгөөд байнгын хяналтанд байх болно. 2 болон 3 дугаар зүйлд заасны дагуу Хавсралтад заасан хувь хүн, хуулийн этгээд, аж ахуйн нэгж, байгууллагын хувьд авах арга хэмжээ нь 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийг хүртэл хэрэгжинэ.

11 дүгээр зүйл

Энэхүү шийдвэр нь *Европын холбооны албан ёсны сэтгүүлд* хэвлэн нийтлэгдсэн дараагийн өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2020 оны 12 дугаар сарын 7-ны өдөр
Брюссель хотод байгуулагдсан.

Зөвлөлийн ерөнхийлөгч
Ж.БОРРЕЛЛ ФОНТЕЛЬС

ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭ
nii.gov.mn